



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 39

Улаанбаатар хот

Хорооны 2010 оны 149 дүгээр тогтоолоор  
батлагдсан журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 149 дүгээр тогтоолоор батлагдсан "Даатгалын байгууллагад аудит хийх үйл ажиллагааг зохицуулах журам"-д дор дурдсан агуулгатай дараах 2 дугаар зүйлийн 13 дахь заалтыг нэмсүгэй.

**1/ 2 дугаар зүйлийн 2.13 дахь заалт:**

"2.13. Журмын 2.10.2-2.10.6-д заасан үндэслэлээр эрх нь хүчингүй болсон аудитын компани 3 жилийн хугацаанд Хороонд дахин хандах эрхгүй."


2. Мөн журмын 1.1 дэх заалтын "сунгах" гэснийг, хоёрдугаар бүлгийн гарчиг дахь "сунгах" гэснийг, 2.4 дэх заалтын "Даатгалын байгууллагад аудит хийх эрх авсан аудитын байгууллагад олгох" гэснийг тус тус хассугай.

3. Мөн журмын 2.4 дэх заалтын "эрхийг 3 жилийн хугацаагаар" гэснийг "эрхийн гэрчилгээ" гэж, 2.7 дахь заалтын "эрх олгох, эрхийг сунгахаас" гэснийг "эрх олгохоос" гэж, 2.8 дахь заалтын "6 сар хүртэл" гэснийг "нэг жилийн" гэж тус тус өөрчилсүгэй.

4. Мөн журмын 2.5, 2.6 дахь заалтуудыг хүчингүй болгосугай.

5. Журамд нэмэлт, өөрчлөлтийг оруулж, хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

008628